



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн
албан татвар, Агаарын бохирдлын төлбөр,
авто зам ашигласны төлбөр хураах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дэх хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалийн хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/304 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүрэгт бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зохион байгуулж, орлогыг төсөвт төвлөрүүлэн, албан татвар, төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлөлтийг хураан барагдуулах, хариуцлага тооцох хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсугай.

2.Дүүрэгт автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр /цаашид албан татвар, төлбөр гэх/ хураах, тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Хуулийн хугацаанд албан татвар, төлбөрөө төлөөгүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй замын хөдөлгөөнд оролцож байгаа автотээврийн хэрэгслийг цагдаагийн албан бие бүрэлдэхүүн биечлэн болон хяналтын камерын тусламжтайгаар илрүүлж, зохих байгууллагад шилжүүлэх, холбогдох газруудыг мэдээллээр ханган хамтарч ажиллахыг “Багахангай Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ (Б.Хишиг-Ундрал), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Замын цагдаагийн хэсэг (Д.Билгээ)-т, дүүргийн төр захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагын албан татвар, төлбөрийг хуулийн хугацаанд Нийслэлийн замын сангийн дансанд төвлөрүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн), Татварын хэлтэс (М.Энхбаяр)-т нарт үүрэг болгосугай.

4.Албан татвар, төлбөр хураах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 774,000 /долоон зуун далан дөрвөн мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Ерөнхий нягтлан бодогч /С.Баасахүү/-д зөвшөөрсүгэй.

5.Албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулж тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ “smartcar.mn” систем, Татварын удирдлагын нэгдсэн систем “e-tax.mta.mn, i-tax.mta.mn” систем, “и-баримт” гар утасны аппликэйшн, гэрэгэ киоск төхөөрөмж ашиглан албан татвар, төлбөр төлөх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлаж албан татвар, төлбөр төлөгчдөд үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэн, дүүрэгт явуулын оношлогоо ирүүлэн аж ахуй нэгж, байгууллага болон иргэдийн бүх тээврийн хэрэгслийг хамруулан ажиллахыг ажлын хэсэг /Х.Цогцэцэг/-т үүрэг болгосугай.


6.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай” Дүүргийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/48 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
4138 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар,
авто замын төлбөр, агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг
зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:	Х.Цогцэцэг	Засаг даргын орлогч
Гишүүд:	Ц.Мягмарсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	М.Энхбаяр	Татварын хэлтсийн дарга
	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа
	Д.Билгээ	Замын цагдаагийн хэсгийн дарга цагдаагийн дэд хурандаа
	Б.Хишиг-Ундрал	Багахангайн Теле камерын хяналтын дэд төв
	Н.Нямзав	ОНӨААТҮГ-ын дарга
Нарийн бичгийн дарга	Б.Батзориг	1-р хорооны Засаг дарга
	С.Бүрэнтөгс	2-р хорооны Засаг дарга
		Татварын улсын байцаагч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 09 -ны өдрийн
4138 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Нийт явах километр	Хэмжих нэгж	100 км-т зарцуулах хэмжээ	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун /АИ92/	2000	Литр	15	300	2580	774,000